

Мөрдвөл зохих 7 дүрэм

1 Вакцин хийлгэсний дараа гараа аль болох ил байлгаж сорвижих үйл явцыг түргэсгэнэ

2 Тарилга хийлгэсэн газраар барьдаггүй сул чөлөөтэй хувцас өмсөнө

3 Тарилга хийлгэсэн газраас бага зэрэг идээ шүүс гарвал хуурай шархны боолтоор бооно

4 ЯМАР Ч ТОС, ТАЛЫК БОЛОН БУСАД ТӨРЛИЙН ЭМ БЭЛДМЭЛ тарилга хийлгэсэн газраа түрхэж болохгүй

5 Ямар ч антибиотик өгч болохгүй

6 Вакцин хийлгэсэн өдөртөө шүршүүрт эсвэл ус дүүргэж усанд орж болно. Харин тарилга хийлгэсэн газраас бага зэрэг идээ шүүс гарч байвал бассейн болон далайн усанд орж болохгүй.

7 Дараах тохиолдлуудад эмчид хандана. Үүнд :


- Тарилга хийсэн газар хүрэхэд 3 см-ээс том гүвдрүү үүсч хавдаж хатуурсан байвал
- Хөдлөхөд зовиуртай байвал
- Гарны булчирхай цочиж томроод, зөөлөрсөн байдалтай байвал (идээлж буглаа үүссэн гэсэн үг)



БЦЖ буюу сүрьеэгийн
вакцины тухай мэдээлэл

Майенны Сүрьегийн Эсрэг Төв
(CLAT 53)

Хаяг
Centre Hospitalier
33 Rue du Haut Rocher
CS 91 525
53000 LAVAL
Утас : 02 43 66 50 55
И-мэйл : clat53@chlaval.fr



Сүрьеэ

Сүрьеэ өвчин нь « Кохын савханцар » гэж нэрлэгддэг нянгаас үүсдэг халдварт өвчин юм. Сүрьеэ нь хүнээс хүнд ханиах, найтаах үед цэр шүлсээр халддаг. Мөн өвчтэй хүнтэй ойр, байнга хамт байснаар халдвар авдаг.



Өвчний шинж тэмдэг юуны өмнө ханиалгах, халуурах, ядрах, хоолны дуршил буурч жин хасах, шөнөдөө хөлрөх гэх мэтээр илэрдэг.



БЦЖ-ийн вакцин




БЦЖ-ийн вакциныг сүрьеэ өвчнөөс хамгаалахын тулд хийдэг. 2007 оноос хойш энэ вакцин нь заавал хийлгэх вакцины тооноос хасагдсан. Тусах эрсдэл өндөртэй 0-15 насны хүүхдэд хийхийг зөвлөдөг.

- Хоруу чанараа алдсан амьд вакцин.
- Энэ вакцины хамгийн гол зорилго нь бага насны хүүхдийг хүнд хэлбэрийн сүрьеэ (сүрьеэгийн менингит, уушигны сүрьеэ) өвчнөөс 75 % хамгаалах юм.
- Вакцин нь сүрьеэ өвчний халдварлалтыг зогсоох, дэлхийн тархалтыг алга болгохгүй.
- 3-аас дээш сартай хүүхдүүдэд сүрьеэгийн сорилыг дархлаажуулалтаас өмнө заавал хийх ёстой. Вакцинжуулалтын дараа сүрьеэгийн сорил хийх шаардлагагүй. Мөн БЦЖ-ийн вакцин давтан хийлгэх шаардлагагүй.
- БЦЖ-ийн вакциныг бусад ямар ч төрлийн вакцинтай хамт нэг өдөр хийж болно.

Дархлаажуулалтын заавар

Дараах тохиолдолд 0-15 насны хүүхдээ вакцинд хамруулахыг танд зөвлөж байна. Үүнд :

- Хэрэв та Иль дө Франс (амьдрах орчин, нөхцөл болон мужаас хамааралгүйгээр), Гуйяан болон Майот аралд оршин суудаг бол
- Таны хүүхэд сүрьеэгийн халдварын тархалт өндөртэй оронд төрсөн бол
- Эцэг эхийнх нь аль нэг нь сүрьеэгийн халдвар өндөр тархсан оронд төрсөн бол
- Таны хүүхэд халдварын тархалт өндөртэй оронд дор хаяж сар болох бол
- Танай гэр бүлийнхнээс сүрьеэ туссан тохиолдол байгаа бол
- Эмч таны хүүхдийг сүрьеэгийн савханцрын нянгаар халдварлах эсрдэл өндөртэй гэж үзвэл



БЦЖ-ийн гаж нөлөө

Ерөнхийдөө БЦЖ-ийн вакцины дараа хариу урвал үзүүлж, халуурах, ядрах гэх мэт шинж тэмдэг илрэхгүй. Харин тарилгын дараа тухайн хэсэгт урвал явагдан, багахан хавдаж, арьс жүржийн хальс шиг бижрүүтэж болно. Энэ шинж тэмдэг нь хэдэн хормын дараа арилдаг.



Вакцины дараах 48 цагт арьс улайж, хатуурч хавдаж болно.

Вакцин хийлгэсэн эхний 3 сард тарилга хийгдсэн хэсгийн арьс хатуурсан хэвээрээ байж болно. Мөн арьс шархалж шингэн идээ гоожиж болно. Вакцины дараа нэлээн хэдэн сарын дараа арьс бүрэн сорвижино. Тарилга хийгдсэн гарын суганд булчирхай цочиж вакцины хариу урвал явагдаж болно.



Вакцинаас сорви заавал үлдэх ёстой